



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

2023

ГАДААД СУВАГ

МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙГАА ОЛОН
СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН
ГАДААД СУВГИЙН МЭДЭЭЛЭЛ

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ОРШИЛ

Телевизийн өргөн нэвтрүүлгийн салбар анх 1928 онд **WRGB** (channel 6) телевизийн суваг АНУ-д туршилтын нэвтрүүлэг цацаж эхэлсэн цаг үеэс маш хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа билээ.

Монгол Улсад телевизийн анхны эфир 1967 оны есдүгээр сарын 27-нд цацагдаж, телевизийн хөгжлийн түүх эхэлсэн байдаг бол 1981 онд анхны өнгөт нэвтрүүлгээ бэлтгэн хүргэж, улмаар 1991 онд Монголын Үндэсний телевиз Азиасат системээр анх удаа орон даяар нэвтрүүлэг цацах боломжтой болж, 2004 оноос телевизийн 4, 2006 оноос 6 сувгийг аймаг, сумын төвүүдэд Радио Телевизийн Сүлжээ УТҮГ-ын сүлжээгээр дахин дамжуулан хүргэж эхэлсэн цаг үеэс Монгол Улсад телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах үндэс суурь тавигдсан гэж хэлж болно. Харин кабелийн телевиз (олон суваг дамжуулах)-ийн үйлчилгээ нэвтэрснээр гадаад улсын телевизийн сувгуудыг хүлээн авч эхэлсэн байдаг.

Монгол Улсад цөөн тооны телевизийн сувгийг үздэг байсан цаг хэдийн өнгөрч технологийн дэвшлийн ачаар үзэгчдийн хүртээл болох гадаад, дотоодын сувгийн тоо эрс нэмэгдэж, үзэгчид өөрийн гэсэн үзэх сувагтай, тогтмол үздэг мэдээ, мэдээллийн хөтөлбөртэй болж, тухайн контентыг үзэх арга, хэлбэр нь ч илүү олон сонголттой болсон. Тухайлбал, хэрэглэгчид таблет, гар утас, компьютер ашиглан хүссэн мэдээллээ интернэтээс авах боломжтой болсон. Гэвч өөрчлөгдөж буй хэвлэл мэдээллийн орчинд уламжлалт телевизийн суваг нь үзэгчдийн нас, хэрэглээ, боловсрол зэргээс үл хамааран нийгмийн бүх давхаргад хамгийн чухал бөгөөд итгэлтэй мэдээлэл хүлээн авах хэрэгсэл байсаар байгаа талаар судалгааны тайлан, дүгнэлтэд дурдсан байдаг.

Үзэгч, сонсогчдын хэрэгцээ шаардлагаар олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээнд холбогдсон телевизийн сувгийн тоо улам нэмэгдэж өнөөдрийн байдлаар Монгол Улсад дотоодын (Улаанбаатар хот, орон нутгийн) нийт 145 телевизийн суваг болон гадаадын 32 улсын 279 гаруй гадаадын телевизийн сувгийн хөтөлбөрийг олон төрлийн сүлжээгээр төрөл бүрийн платформ ашиглан хүлээн авч байна.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд олон суваг дамжуулах үйлчилгээний нийт 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас Улаанбаатар хотод 13, орон нутагт 17 үйлчилгээ эрхлэгчид төрөл бүрийн технологи ашиглан үйл ажиллагаа эрхэлж, гадаад дотоодын олон сувгийг хэрэглэгчид хүргэж байна.

Харилцаа холбооны технологи хувьсан өөрчлөгдөж, олон суваг дамжуулах үйлчилгээний технологи ч мөн шинэчлэгдэж, кабелийн технологиос интернэтэд суурилсан шинэ үеийн дэвшилтэд телевизийн технологи (OTT) өргөжин тэлж байна. Өндөр хурдны интернэт айл өрх бүрд хүрэхийн хэрээр хэрэглэгчид олон төрлийн телевизийн суваг, контентуудыг тогтсон хөтөлбөр, байршил, төхөөрөмжид баригдахгүйгээр чөлөөтэй хүлээн авч үздэг болсон.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь гадаад улсын радио, телевизийг дамжуулахдаа албан ёсны эрхийг нь авсан, Зохицуулах хороонд бүртгүүлсэн байх бөгөөд хөтөлбөр нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байх шаардлагыг хангах үүрэг хүлээсэн байдаг. Иймд Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад улсын телевизийн сувгийн харьяалал, хөтөлбөртэй холбоотой холбогдох мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны

өмчийн газрын даргын 2021 оны А/26 - А/13 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, дэлгэрэнгүй тайлан мэдээ гаргаж, цахим хуудсаараа тогтмол мэдээлэн ажиллаж байна.

Энэхүү тайлангаар Зохицуулах хорооноос гадаад улсын телевизийн сувгийн бүртгэл, мэдээллийг 2022 оны байдлаар шинэчилж, нэгтгэн гаргаснаа хүргэж байна.

ГАДААД СУВГИЙН БҮРТГЭЛ


Монгол Улсад 2022 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын 13, орон нутгийн 17, нийт 30 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид 32 орны 279 телевизийн гадаад сувгийг дахин дамжуулж байна.

Гадаад сувгийн 2021 оны бүртгэлийн тайланд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн гадаад сувгийн мэдээлэл гарч байсан бол энэ оны тайланд Улаанбаатар хот төдийгүй орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 28 үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгуудын мэдээлэл орсон байгаагаар онцлог юм. Судалгаанд хамрагдаагүй 2 үйлчилгээ эрхлэгч нь гадаад суваг дахин дамжуулдаггүй, үйл ажиллагаа эхлээгүй үйлчилгээ эрхлэгчид байсан.

Нийт сувгийн 40,43% хувь нь ОХУ-ын телевизийн суваг байсан ба нийт 304 телевизийн суваг байна. Харин Австрали, Австри, Афганистан, Люксембург болон Португал улсын сувгууд 1 байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод хамгийн их ОХУ-н телевизийн сувгийг дахин дамжуулж байгаа ОСДҮЭ хувьд Скаймедиа корпорац ХХК нь ОХУ-н 21, Талст эрчим ХХК нь ОХУ-н 20 телевизийн сувгийн тус тус дахин дамжуулж байгаа бол орон нутгаас Увс аймгийн Дөрвөн шарга ХХК нь ОХУ-н 37, Ховд аймгийн Хаан Алтай Ховд ХХК нь ОХУ-н 27 телевизийн сувгийг тус тус дахин дамжуулж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд ОХУ-ын суваг 2021 оны тайланд 32% байсан бол 2022 онд өссөн үзүүлэлттэй байна. Шалтгаан нь орон нутгийн 17 үйлчилгээ эрхлэгчдийг судалгаанд хамруулсан бөгөөд дамжуулж байгаа сувгуудын дийлэнх нь ОХУ-н телевизийн сувгууд буюу 48.7% хувийг эзэлж байгаатай холбоотой.

Газар зүйн бүсээр нь авч үзвэл Ази тивийн телевизийн сувгууд олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр хамгийн их дахин дамжиж байгаа бөгөөд нийт 179 суваг байгаагаас Юнивишн ХХК нь Ази тивийн 75 сувгийг дахин дамжуулж байна. Харин Африк тивээс Оптимум ХХК-н сүлжээгээр дахин дамжиж байгаа Арабын нэгдсэн Эмират улсын Dubai Sports, Dubai TV International гэсэн 2 телевиз хамгийн бага буюу нийт сувагт эзлэх хувь нь 1% байна.



Зураг 1: Гадаад сувгийн эзлэх хувийг бүсээр нь харуулав

МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙГАА ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ДАХИН ДАМЖУУЛЖ БАЙГАА ГАДААД СУВАГ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх нийт 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 2022 оны байдлаар 28 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үндсэн болон нэмэлт багцууддаа нийт **32** орны **279** гадаад суваг дахин дамжуулж байгаагаас Улаанбаатар хотод Юнивишн ХХК нь хамгийн их буюу 23 орны 106 гадаад сувгийг хүлээн авч дахин дамжуулж байна. Харин орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдээс Баян-Өлгий аймгийн ЖСММ ХХК-нь хамгийн их буюу 6 орны 49 гадаад суваг, Увс аймгийн Дөрвөн шарга ХХК нь 8 орны 47 гадаад суваг, Ховд аймгийн Хаан Алтай Ховд ХХК нь 9 орны 43 сувгийг тус тус дамжуулж байна.

Хүснэгт 1: Улаанбаатар хотын ОСДҮЭ-н дахин дамжуулж байгаа гадаад сувгийг харьяалал болон тоогоор авч үзвэл.

№	ОСДҮЭ-н нэр	Гадаад сувгийн тоо	Гадаад сувгийн харьяалал - Улс
1	Шинэ сансар кабель ХХК	21	9
2	Монголын цахилгаан холбоо ХК	30	8
3	Сансар Дижитал ХХК	17	8
4	Эн Би Си ХХК	49	15
5	Оптимум нэтворк ХХК	34	12
6	Юнивишн ХХК	106	23
7	Скаймедиа корпораци ХХК	61	14
8	ДДэш ТВ ХХК	51	11
9	Монголсат нэтворкс ХХК	23	5
10	Мобинет ХХК	18	6
11	Талст эрчим ХХК	27	6

Хүснэгт 2: Орон нутгийн ОСДҮЭ-н дахин дамжуулж байгаа гадаад сувгийг харьяалал болон тоогоор авч үзвэл.

№	ОСДҮЭ-н нэр	Гадаад сувгийн тоо	Гадаад сувгийн харьяалал - Улс
1	Эм Эм Ди Эс ХХК	13	9
2	Лха хөх тэнгэр ХХК	13	4
3	Агаарын суваг ХХК	20	8
4	Гал саятан ХХК	11	3
5	Дөрвөн шарга ХХК	47	8
6	Хаан Алтай Ховд ХХК	43	9
7	Би Ти Жи ХХК	9	5
8	Өвөр даваат ХХК	13	8
9	Цацраг трейд ХХК	27	8
10	Мандалширхэнцэг ХХК	11	8
11	Орхон систем ХХК	7	5
12	Ди Би Эс Си ХХК	11	6
13	Мөнхсаран Чулуу ХХК	12	2
14	ЖСММ ХХК	49	6
15	Дархан ширхэнцэг ХХК	17	8
16	Халиун кабель ХХК	9	8
17	Наран гүрт ХХК	11	2





График 1: Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа ОСДҮЭ-н дамжуулж байгаа Гадаад сувгийг тоогоор нь харуулав.



Зураг 2: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа нийт гадаад сувгийн тоог Улаанбаатар хот, Орон нутгаар нь ангилж, хувиар илэрхийлбэл.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийг төрлөөр нь авч үзэхэд утастай, утасгүй сүлжээгээр ОСДҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй буюу DVB-T2 технологиор олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь хамгийн их гадаад сувгийг дамжуулж байна. Учир нь DVB-T2 технологиор олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн тоо нь бусад үйлчилгээ эрхлэгчдээс харьцангуй их буюу 61% хувь байна. Улаанбаатар хотод DVB-T2 технологиор үйлчилгээ эрхэлж буй 4 үйлчилгээ эрхлэгч байсан бол орон нутгийн 17 үйлчилгээ эрхлэгч байна.




График 2: Гадаад суваг дамжуулж буй ОСДҮЭ-г төрлөөр нь авч үзвэл.

Дахин дамжуулж байгаа гадаад улсын харьяалал:

Монгол Улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа сувгуудыг авч үзэхэд 1 үйлчилгээ эрхлэгч дунджаар 30 гадаад суваг, хамгийн багадаа 7, хамгийн ихдээ 106 суваг дамжуулж байгаагаас гадаад улсын харьяаллыг улсаар авч үзэхэд нийт 32 улс байна.

Баян-Өлгий аймгийн хувьд Казах хилээр ярьдаг, Казахстан улстай хил залгаа байдаг учир Казахстан, ОХУ-н телевизийн суваг тус аймгийн хувьд хамгийн их байна. Мөн судалгааны явцад Дорнод аймгийн үйлчилгээ эрхлэгчээс ОХУ-н телевизийн сувгийн тоог нэмэгдүүлэх боломжтой эсэхийг асууж байсан зэргээс үзэхэд газарзүйн онцлогоос хамаарч манай улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгуудаас аль нэг улсын телевизийн суваг нь давамгайлах хандлагатай байна. Түүнчлэн бусад аймгуудад дамжиж байгаа гадаадын телевизийн сувгуудын дийлэнх хувийг ОХУ-н телевизийн суваг эзэлж байгаа нь хиймэл дагуулын төлбөргүй сувгууд их байгаатай холбоотой байна.

Улаанбаатар хотын ОСДҮЭ-н хувьд 31 улсын нийт 429 телевизийн сувгийг давхардсан тоогоор дахин дамжуулж байна. Үүнээс ОХУ-н 144 телевизийн сувгийг хамгийн их дахин дамжуулж байгаа нь нийт сувагт эзлэх хувь нь 35.6% байна. Харин Австрали, Австри, Люксембург, Португал, Турк, Энэтхэг зэрэг улсын телевизийн 1 суваг дамжиж байгаа нь Улаанбаатар хотод дахин дамжиж байгаа нийт гадаад сувгийн хамгийн бага хувийг эзэлж байна.

Юнивишн ХХК нь гадаадын 106 телевизийн сувгийг өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа нь Улаанбаатар хотод дамжуулж байгаа нийт 429 гадаад сувгийн 24.71%-г эзэлж байна.

Хүснэнгт-3: Улаанбаатар хотод ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгуудыг улсаар нь харуулав.

№	НЭР	УЛААНБААТАР ХОТ											Нийт
		Шинэ сансар кабель ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	Сансар Дижитал ХХК	Эн Би Си ХХК	Оптимум нэтворк ХХК	Юнивишн ХХК	Скаймедиа корпораци ХХК	ДДэш ТВ ХХК	Монголсат нэтворкс ХХК	Мобинет ХХК	Талст эрчим ХХК	
1	Австрали							1					1
2	Австри				1								1
3	Англи		1	1					2			2	6
4	АНУ		2		7	5	9	10	11	1	4	1	50
5	Араб					2		1					3
6	БНСУ	2		1	1	2	3	3	2			1	15
7	БНХАУ		1	4	2	5	9	8	3			2	34
8	Болгар						1		1				2
9	Герман	1	1	1	1	1	3	2	1	1		1	13



10	Испани	1			1		1	1					4
11	Итали	1		1			1	1					4
12	Их Британи		5		2		4	4					15
13	Казакстан				1		2	1	4				8
14	Канад						2						2
15	Катар	1		1	1		1						4
16	Киргизстан						10						10
17	Люксембург						1						1
18	Макао				1		1						2
19	ОХУ	12	18	6	17	12	11	21	7	16	4	20	144
20	ӨМӨЗО					1	1						2
21	Пакистан						3						3
22	Португаль						1						1
23	Сингапур	1	1		1		30	1	14	4	2		54
24	Турк				1								1
25	Украйн						3						3
26	Франц	1		2	3	1	5	5	5		1		23
27	Хонконг					1	2						3
28	Швед					2							2
29	Шинэ Зеланд										6		6
30	Энэтхэг					1							1
31	Япон	1	1		1	1	2	2	1	1	1		11
Нийт		21	30	17	41	34	106	61	51	23	18	27	429

Орон нутгийн ОСДҮЭ-н хувьд 19 улсын нийт 323 телевизийн сувгийг давхардсан тоогоор дахин дамжуулж байна. Үнээс хамгийн их дамжуулж байгаа гадаадын суваг нь ОХУ-н буюу давхардсан тоогоор нийт 160 суваг байна. Энэ нь орон нутагт дамжуулж байгаа нийт гадаадын сувгийн 49,5%-г эзэлж байна. Харин Афганистан, Канад, Сингапур зэрэг улсын телевизийн 1 суваг дамжиж байгаа нь орон нутагт дахин дамжиж байгаа нийт гадаад сувгийн хамгийн бага хувийг эзэлж байна.

Орон нутгийн ОСДҮЭ-д нь харьцангуй бага гадаад сувгуудтай байгаа нь дийлэнх нь нэмэлт багц байхгүй тул “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын дагуу гадаад сувгийн тоог хувь хэмжээнд хүргэсэн. Харин 40-с дээш тооны гадаад суваг дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгчид нь нэмэлт багцтай байна. Үүнд:

- ЖСММ ХХК нь хамгийн их буюу 49 гадаад суваг дахин дамжуулж байгаа ба үүнээс дийлэнх нь Казахстаны 17, ОХУ-н 16 телевизийн сувгууд эзэлж байна.
- Дөрвөн шарга ХХК нь нийт 47 гадаад суваг дамжуулж байгаагаас хамгийн их нь ОХУ-н 37 телевизийн суваг байгаа бол АНУ, БНСУ, БНХАУ, ӨМӨЗО, Франц, Швед зэрэг улсын 1 телевизийн суваг дахин дамжуулж байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна.
- Хаан алтай ховд ХХК нь нийт 43 гадаад сувагтай ба үүнээс хамгийн их нь ОХУ-н 27 телевизийн суваг байгаа бол АНУ, БНСУ, Швед, Япон зэрэг улсын 1 телевизийн суваг байгаа нь тухайн ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа хамгийн бага гадаад суваг болж байна.

Хүснэгт-4: Орон нутагт ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгуудыг улсаар нь харуулав.

№	НЭР	ОРОН НУТАГ															Тоо	
		Эм Ди Эс ХХК	Лха хөх тэнгэр ХХК	Агаарын суваг ХХК	Гал саятан ХХК	Дөрвөн шарга ХХК	Хаан Алтай Ховд ХХК	Би Ти Жи ХХК	Өвөр даваат ХХК	Цацраг трейд ХХК	Мандалширхэнцэг ХХК	Орхон систем ХХК	Ди Би Эс Си ХХК	Мөнхсарн Чулуу ХХК	ЖСММ ХХК	Дархан ширхэнцэг ХХК		Халиун кабель ХХК
1	Англи		1	3	1	4	3	1		2				10			2	28
2	АНУ	1	3	6		1	1	1		1		2		3	1	2		22
3	Афганистан							1										1
4	БНСУ	1				1	1		1	1	1			1	1	1		10
5	БНХАУ	2		1	1	1	2	3	3	6	2		3	2	2	3	1	32
6	Герман	1							1	1	1	1						5
7	Испани								1		1							2
8	Итали								1		1							2
9	Их Британи			1													1	2
10	Казахстан			1			5							17	2			25
11	Канад														1			1
12	ОХУ	4	8	6	9	37	27	3	3	13	2	2	3	10	16	7	1	160
13	ӨМӨЗО	1	1			1			1	2	1	1			1	1		10
14	Сингапур																1	1
15	Турк												2					2
16	Франц	1				1	2		2	1	2		1				1	11
17	Швед					1	1											2
18	Энэтхэг	1		1									1					3
19	Япон	1		1			1									1		4
Нийт		13	13	20	11	47	43	9	13	27	11	7	11	12	49	17	9	323




График-3: ОСДҮЭ-н сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд




График-4: ОСДҮЭ-н сүлжээгээр хамгийн бага дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.

Монгол Улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийг улсын харьяаллаар нь авч үзэхэд ОХУ-н телевизийн суваг хамгийн их буюу 304 байгаа нь Монгол Улсад дамжиж байгаа нийт гадаад сувгийн 40.43%-тай тэнцүү байна. Португал, Люксэнбург, Афганистан, Австри, Австрали зэрэг улсын телевизийн 1 суваг дамжиж байгаа нь нийт сувгийн хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүснэгт-5: ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад Сувгуудыг тоогоор харуулав.

ОСДҮЭ-н нэр	УЛААНБААТАР ХОТ										ОРОН НУТАГ																	
	Шинэ сансар кабель ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	Сансар Дижитал ХХК	Эн Би Си ХХК	Оптимум нэтворк ХХК	Юнвишн ХХК	Скаймедиа корпораци ХХК	ДДэш ТВ ХХК	Монголсат нэтворк ХХК	Мобинет ХХК	Талст эрчим ХХК	Эм Эм Ди Эс ХХК	Ла хөх тэлгэр ХХК	Агаарын суваг ХХК	Гал салтан ХХК	Дөрвөн шарга ХХК	Хан Алтай Хөвд ХХК	Би Ти Жи ХХК	Өвөр далаат ХХК	Цацраг трейд ХХК	Мандлширхэнцэг ХХК	Орхон систем ХХК	Ди Би Эс Си ХХК	Мөнхсари Чулуу ХХК	ЖСММ ХХК	Дархан ширхэнцэг ХХК	Хөлүүн кабель ХХК	Нараан гурт ХХК
Сувгийн тоо	21	30	17	41	34	106	61	51	23	18	27	13	13	20	21	47	43	9	13	27	11	7	11	12	49	17	9	11

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад суваг бүрийг авч үзвэл: ОХУ-н хүүхдийн телевизийн суваг болох Карусель нь хамгийн их буюу 20 ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжиж байна. Харин 24 улсын 137 телевизийн суваг хамгийн бага буюу 1 ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжиж байна.

Хүснэгт-6: ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад суваг бүрийг авч үзвэл.

№	Гадаад сувгийн нэр	ОСДҮЭ-н тоо	№	Гадаад сувгийн нэр	ОСДҮЭ-н тоо	№	Гадаад сувгийн нэр	ОСДҮЭ-н тоо
1	ABC Australia	1	55	NBA	1	109	BBC Lifestyle	3
2	Viasat History	2	56	MTV HITS	1	110	BBC world news	7
3	AMEDIA	5	57	Dubai Sports	1	111	Cbeebies	3
4	Da Vinci Learning	2	58	Dubai TV International	1	112	Kazakh TV	5
5	Discovery	5	59	mfa asia	1	113	Астана	3
6	Galaxy	4	60	Arirang	14	114	Казахстан	3
7	VIP PREMIERE	2	61	YTN	4	115	Balapan	3
8	Travel xp	1	62	KBS World	5	116	Хабар -24	2
9	HCTB	1	63	CCTV10	2	117	Каз спорт	2
10	VIP megakhit	1	64	CCTV4	6	118	Хабар	2
11	VIP COMEDY	1	65	CGTN Documentary	4	119	Ел арна	1
12	CNN international	1	66	Channel V	4	120	Ктк	1
13	Warner TV	2	67	CCTV2	1	121	Занал-31	1
14	Nickelodeon	5	68	CCTV15	1	122	НТК	1
15	MTV	3	69	CCTV5+	1	123	СТВ	1
16	AXN	1	70	CGTN RUS	3	124	Алматы тв	1
17	JimJam	1	71	NMTV-1	1	125	Жети су	1
18	Paramount channel	1	72	CCTV5	3	126	Гакку тв	1
19	Red	1	73	MNTV	1	127	Талим ТВ	1
20	Black	1	74	XJTV	2	128	Той думан	1
21	Viasat Explore	2	75	Lotus TV Macau	8	129	Туран	1
22	Cartoon network	8	76	CGTN	3	130	Classica	1
23	Disney	5	77	CGTN Espaniol	1	131	Stingray Cmusic	1
24	National geographic	9	78	CGTN Arabic	1	132	Aljazeera	6
25	Travel+	1	79	CGTN Francais	1	133	Время ТВ	2
26	Nat Geo Wild	8	80	Phoenix TV	3	134	Бабер	1
27	Boomerang	4	81	PHX Chinese Channel	1	135	Luxe TV	2
28	History channel	2	82	PHX HK Channel	1	136	Первый канал	7
29	Life time	2	83	CCTV-14	3	137	Карусель	20
30	Animal planet	3	84	XING KONG	1	138	Дом кино	9
31	Travel channel	2	85	NTN TV	1	139	Поехали	4
32	Food network	2	86	NNTV	1	140	Звезда	9
33	HGTV	2	87	RTG tv	1	141	Матч	11
34	HBO	2	88	Хонгконг	1	142	НТВ	14
35	HBO family	2	89	CCTV1	2	143	Охота И Рыбалка	10
36	HBO hits	2	90	CCTV movie	1	144	РЕН ТВ	13
37	HBO signature	2	91	CCTV-9	1	145	Россия1	9
38	Cinemax	2	92	DTV8	1	146	ТНТ	9
39	MTV live	2	93	CCTV R	1	147	Sony Sci Fi	4
40	Playboy	2	94	XJTV-3	2	148	Ocean TV	4
41	CNN	3	95	XINJIANG TV	1	149	Моя планета	7
42	SM TV	2	96	Lolly Kids	2	150	НБК Саха	1
43	Outdoor	1	97	Deutsche Welle	11	151	Multi	2
44	Rock Entertainment	1	98	DW in English	6	152	ОРТ	5
45	Rock extrem	1	99	Motorvision	1	153	RUS-1	1
46	Bloomberg	2	100	DW in Germany	1	154	Загородная Жизнь	1
47	Voice of America	1	101	TVE	5	155	Футбол	3
48	BBG	1	102	Hollywood	1	156	Кино Хит	2
49	SPS prime	1	103	Rai italia	4	157	Paramount Comedy	1
50	SPS plus	1	104	ARI	2	158	Индия	1
51	SPS Play	1	105	DocuBox	1	159	Vremya: daleкое I blizкое	2
52	National TV	1	106	Sony Turbo	1	160	Muzika Pervogo	3
53	RT	1	107	Extreme sport	4	161	Дом кино премиум	5
54	Premier спорт	1	108	BBC Earth	3	162	O!TV	6

163	Телекафе	4	202	Start	2	241	Channel News Asia	3
164	Bober	2	203	Наша Тема	1	242	Discovery Science	2
165	Победа	6	204	Солнце	1	243	EVE	2
166	RT news	1	205	Кино сат	1	244	DMAX	3
167	M1-Global/MMA-TV	1	206	CTC kids	1	245	C&I network Asia	1
168	Русский ночь	1	207	Россия24	1	246	Asian food channel	1
169	Детский мир	3	208	DIKI	1	247	TLC	1
170	Любимой Кино	3	209	YU TB	1	248	Spotv 1	1
171	Перец	2	210	Матч Боец	1	249	Spotv 2	1
172	СТС	8	211	РБК	1	250	TRT World	1
173	Канал 5	1	212	Мыр	1	251	TRT Çocuk	1
174	Active life	1	213	Zoo	1	252	TRT avaz	1
175	Wild Nature	2	214	Страна купер	1	253	Current time	1
176	Tourist eye	1	215	СМС	1	254	Freedom YV	1
177	OPT Eurasia	1	216	TV XXI	1	255	Espreso TV	1
178	2x2	1	217	TV1000 Megahit	1	256	Trace Urban	4
179	OPT1	7	218	TV1000 COMEDY	1	257	France 24	6
180	KHL TV	4	219	МУЗ	3	258	Euro News	6
181	Диалоги рыбака	1	220	Gagsnetwork	1	259	Fashion TV	8
182	ТВЗ	9	221	Канал-7	1	260	Euro Sport	9
183	Матч Арена	2	222	Euro Asia	1	261	TV5 Monde	7
184	Матч Игра	2	223	Matsh-1	1	262	Trace sport starts	3
185	Осторожны Кино	1	224	TV1000 Action	1	263	TV5 Monday Asia	3
186	Блок Бастер	1	225	Шансон TV	1	264	Fox news	1
187	O La La	1	226	VH1 Classic	1	265	OGTN	1
188	Домашний	2	227	Мужское кино	3	266	TV1000	7
189	Ru TV	2	228	Spike	1	267	Viasat Nature	5
190	ТНТ4	2	229	ЧЕ	1	268	Viasat Sport	4
191	Пятница	2	230	Zbezda	1	269	Pulse Documentary	1
192	ТВ центр	2	231	NMTV	3	270	Rialto channel	1
193	ЦТВ	1	232	Өвөр Монгол	9	271	Pet Club TV	1
194	ТНТ comedy	1	233	Nei Mongol	2	272	Now 80's	1
195	Friday	1	234	Одон ТВ	1	273	Now 90's	1
196	Матч планета	2	235	Ary news Asia	1	274	ETC Bollywood	1
197	ТВД	1	236	Ary Musik	2	275	ANIMAX	1
198	Leomax 24	1	237	Ary Zindagi	1	276	NHK World	8
199	Кино ТВ	2	238	RTP Gravada	1	277	NHK	4
200	Zee Russia	4	239	CNA	2	278	NHK world premium	3
201	Клон	1	240	Baby TV	5	279	CCTV	3

Хүснэгт-7: ОСДҮЭ-н сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаадын 10 телевизийн сувгийн мэдээллийг хүснэгтээр үзүүлэв.

№	Гадаад сувгийн нэр	Эзэмшигчийн харьяалал (улс)	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн нөхцөл	HD/SD	Сигналын эх үүсвэр	Сувгийн төрөлжилт, чиглэл - Монголоор	Хөтөлбөрийн хэл	Дахин дамжиж буй ОСДҮЭ-ийн тоо
1	Карусель	ОХУ	Багцын төлбөртэй	SD	ABS2A V	Хүүхдийн	Орос	20
2	Arirang	БНСУ	төлбөргүй	SD	intelsat 19V	Танин мэдэхүй	Солонгос/Англи	14
3	НТВ	ОХУ	Төлбөртэй	SD	Express AM5	Танин мэдэхүй	Орос	14
4	РЕН ТВ	ОХУ	Төлбөртэй	SD	Хиймэл дагуул	Танин мэдэхүй	Орос	13
5	Deutsche Welle	Герман	Төлбөргүй	SD	Asiasat 7	Мэдээний	Англи	11
6	Матч	ОХУ	Төлбөртэй	SD	Express AM5	Спорт	Орос	11
7	Охота И Рыбалка	ОХУ	Төлбөртэй	SD	Express AM5	Ан агнуур	Орос	10
8	National geographic	АНУ	Төлбөртэй	SD	Asiasat 7	Танин мэдэхүй	Англи	9
9	Дом кино	ОХУ	Төлбөртэй	SD	CAM	Кино	Орос	9
10	Euro Sport	Франц	Багцын төлбөртэй	SD	Intelsat 19V	Спорт	Англи	9

Дамжуулж байгаа гадаад сувгийн хэл:

Монгол Улсад дахин дамжуулж байгаа гадаадын телевизийн сувгуудыг ямар хэл дээр дамжуулж байгаа талаар судлахад 23 улсын хэл дээр 32 улсын 279

телевиз байна. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь газарзүйн онцлогоос шалтгаалан гадаад сувгийг өөр өөр хэл дээр дамжуулж байна. Жишээ нь: Lotus TV Масау сувгийг Англи, Хятад, Орос хэл дээр тус бүр дамжуулж байна. Иймд доорх хүснэгтэд хэлний төрлөөр нь гадаад суваг тус бүрээр нь ангилж, нэгтгэн тоог гаргасан. Орос хэлээр давхардсан тоон 331 гадаад сувгийг 28 ОСДҮЭ-д өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь 43.61% байна. Харин Англи хэл дээр 221 гадаад сувгийг дамжуулж байгаа нь нийт гадаад сувагт эзлэх хувь нь 29.12% байна.

Хүснэгт-8: ОСДҮЭ-н сүлжээгээр дамжиж байгаа гадаад сувгуудыг хэлний төрлөөр (хамгийн өндөр дүнтэй 10 улсыг) нь авч үзэхэд:

№	Нэр	Тоо	Хувь
1	Орос	331	43.61%
2	Англи	221	29.12%
3	Хятад	40	5.27%
4	Казах	24	3.16%
5	ӨМӨЗО	22	2.90%
6	Солонгос	19	2.50%
7	Франц	19	2.50%
8	Орос/Англи	15	1.98%
9	Герман	12	1.58%
10	Казах, Орос	12	1.58%




График-5: ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг хэлний төрлөөр нь нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.

Гадаад сувгийн төрөл:

Монгол Улсад олон суваг дамжуулах 28 үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр давхардсан тоогоор нийт 752 гадаадын суваг дахин дамжиж байгаагаас 156 нь буюу 20.42% хувь нь танин мэдэхүйн телевиз байна. Харин хүүхэд, залуусын боловсролд чиглэсэн төрөлжсөн хөтөлбөртэй боловсролын 2 телевиз (CCTV10, Моя планета) нь 3 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байгаа нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хангалтгүй байна.

Монгол Улсын хэмжээнд боловсролын төрөлжсөн хөтөлбөртэй дотоодын 1, гадаадын 2 телевиз байгаа нь маш бага тоон үзүүлэлтийг харуулж байна

Хүснэгт-9: Давхардсан тоогоор дамжуулж байгаа сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд:

Төрөл	Амьдралын хэв маяг, соёл	Ан агнуур	Аялал жуулчлал	Баримтаг	Боловсрол	Загвар	Кино	Мэдээний	Насанд хүрэгчдэд	Нийгэм эдийн засаг	Олон талт хөтөлбөрт	Спорт	Танин мэдэхүй	Төл худалдаа	Хөгжим	Хүүхдийн	Хөгжөөнт
Тоо	37	14	4	23	7	8	69	114	3	6	122	70	156	2	38	76	3
Хувь	4.9%	1.9%	0.5%	3%	1%	1.1%	9.2%	15.1%	0.4%	0.8%	16%	9.3%	21%	0.3%	5%	10.1%	0.4%

ДҮГНЭЛТ

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, тус хорооны 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоолоор батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 5.5-д заасны дагуу өөрийн сүлжээгээр дамжуулах гадаад сувгийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны өмчийн газрын даргын 2021 оны А/26 - А/13 тоот тушаалаар хамтран баталсан маягтын дагуу ирүүлэх ба албан ёсны эрхийн хугацаа дуусаж, сунгасан бол тухай бүр шинэчлэн ирүүлэх шаардлагатай байдаг.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй олон суваг дамжуулах 30 үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 13, орон нутагт 17 үйлчилгээ эрхлэгч байна. Үүнээс үйл ажиллагаа эхлээгүй 1, гадаад суваг дахин дамжуулдаггүй 1 үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 08/94 тоот албан бичгээр гадаад сувгийн мэдээллийг ирүүлэх хүсэлтийн дагуу 28 үйлчилгээ эрхлэгч нь гадаад сувгийн мэдээллийг ирүүлж 100% хувийн биелэлттэй судалгааны үр дүнг нэгтгэн гаргасан.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгийг бүртгэх ажлыг 2020 онд анх зохион байгуулж, 2021

оны 1-р улиралд “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн гадаад сувгуудыг бүртгэсэн тухай” дэлгэрэнгүй тайлан мэдээ гаргаж, цахим хуудсаараа мэдээлж ажилласан. Харин энэ жилийн судалгаанд орон нутгийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хамрагдсанаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа нийт гадаад сувгийн тоо, ямар улсын, ямар төрөл хөтөлбөртэй, эсэх мэдээллүүдийг нэгтгэж, олон нийтэд ил тод мэдээлэх боломж бий болж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.1-т өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах гэж заасны дагуу үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн гадаад сувгийн мэдээлэлд үндэслэсэн энэхүү судалгааг Оюуны өмчийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.